



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

2007 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Дархан

Дугаар 16

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. “Тайван орчин” аймгийн хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг хөтөлбөрийн хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн орон нутгийн төсөв, төлөвлөгөөнд тусган, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГҮНЧИН